

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүүхдийн эсрэг зарим гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх, бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах, бага насны хүүхдийн насны хязгаарыг нэмэгдүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан үйлдэлд оногдуулах ялыг чангаруулах, согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон үйлдэлд оногдуулах ялын бодлогыг чангаруулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан бөгөөд уг хуулийн төсөл батлагдсанаар материаллаг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тул зардал үүсэхгүй гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаагаа илэрхийлж, хуулиар мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийг зөвхөн шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч гэсэн хүрээнд хамааруулж байсныг хавтгайруулан тухайн мөрдөн шалгах ажиллагааны нууцыг олж авч мэдсэн хүн гэдэг агуулгаар томьёолсон нь зөв эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах хуулийн төслийг нэн яаралтай горимоор өргөн мэдүүлж, хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохтой холбоотой зөрчил, гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн талаарх асуудлыг нэн яаралтай оруулж ирж байгаа үндэслэл шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн хүчиндэх гэмт хэрэг болон, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогын ялгаатай байдал болон энэ гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зураг, мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож зөрчил гаргаж байгаа хүмүүсийн нас, хүйсийн талаар судалгаа байгаа эсэх, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт эцэг, эх байх, халамжлах үүргээ гүйцэтгээгүй, бага насны хүүхэдтэй зүй бусаар харьцсан, хүүхдийг хүчээр хөдөлмөрлүүлэх гэх

мэт асуудлыг бүрэн тусгаж цогцоор оруулж ирэх боломж байгаа эсэх, хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан торгох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлэх тухай асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган батлуулж байсан талаар онцлоод, хууль санаачлагчаас согтууруулах ундаа хэрэглэсэн, түүнийг шалгаж, тогтоох ажиллагааны үр дүнд шалгуулагчийн амьсгал болон цусан дахь спиртийн агууламжийг хэрхэн тооцон гаргадаг талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг уг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаагаа илэрхийлээд, гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг анхаарч Тахарын албыг дахин байгуулах хууль эрх зүйн боломж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат сэтгэцийн эмгэгтэй хүн бага насны хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар бага насны хүүхдийн насны дээд хязгаарыг нэмэгдүүлж байгаа шалтгаан нөхцөл, 14-16 насны хүүхдийг бага насны ангилалд оруулахад Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заасан иргэний эрх зүйн бүрэн чадамжтай нийцэж байгаа эсэх, тэдгээр хүүхдийн эрх хумигдаж байгаа эсэх, мөн нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн хуулийн төслийн дагаж мөрдөх хугацааг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан нь зөв эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.


Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.ЦОГТБААТАР